


Улаанбаатар БҮК” ХК-ийн “Бизнесийн ёс зүйн дүрэм”



**“УЛААНБААТАР БҮК” ХК-ИЙН ОРОЛЦОГЧТАЛУУДАЙ
ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО**

2023 он

АГУУЛГА

Нэг.Нийтлэг үндэслэл	3
Хоёр. Оролцогч талууд	3
Гурав. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах	4
Дөрөв. Бодлогын хэрэгжүүлэлт	4
Тав. Хяналт, сайжруулалт, өөрчлөлт оруулах.....	4

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
12. Энэхүү бодлогын зорилго нь “Улаанбаатар БҮК” ХК (цаашид “Компани” гэх)-ийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах харилцааг зохицуулахад орших ба харилцах, хамтран ажиллах явцад гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэтгэл ханамжтай хамтын ажиллагааг бий болгоход оршино.


ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- 2.1. Оролцогч талууд гэж компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлж буй талуудыг /хувь хүн, бүлэг, байгууллага/ хэлнэ.
- 2.2. Компанийн оролцогч талуудад дараах этгээд хамаарна:
 - 2.2.1 Хувьцаа эзэмшигчид
 - 2.2.2 Ажилчид
 - 2.2.3 Хэрэглэгчид
 - 2.2.4 Төлөөлөн удирдах зөвлөл
 - 2.2.5 Ханган нийлүүлэгчид
 - 2.2.6 Банк санхүүгийн байгууллагууд
 - 2.2.7 Төрийн байгууллагууд
 - 2.2.8 Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд
 - 2.2.9 Төрийн бус байгууллагууд
 - 2.2.10 Өрсөлдөгчид
 - 2.2.11 Боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд
- 2.3. Компаний үйл ажиллагаа оролцогч талуудаа тодорхой нөлөө үзүүлдэг мөн оролцогч талууд компанийн үйл ажиллагаанд өөрсдийн нөлөөг үзүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрч, эрх ашгийг нь хүндэтгэн, хамтран ажиллана.
- 2.4. Компани нь оролцогч талуудтай хамтран ажиллахдаа хууль, дүрэм журам, шударга ёс, ёс зүйн хэм хэмжээг баримтална.
- 2.5. Оролцох талуудын хамаарал, ач холбогдлыг тодорхойлохдоо оролцогч тал тус бүрд тохирсон хэрэгцээ, хүлээлтийн шинжилгээ хийнэ. Хэрэгцээ, хүлээлтийн шинжилгээнд үндэслэн оролцогч тал тус бүртэй харилцах, хамтран ажиллах стратегийг боловсруулна.

ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ

- 3.1. Оролцогч талуудын бүлэг, ангилал бүрээр тэдгээрт тохирсон харилцах, хамтран ажиллах стратеги, арга хэлбэр, журамтай байна.
- 3.2. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллахдаа “Оролцогч талуудын оролцооны зураглал, матриц”-ыг ашиглана. /Зураг 1/

“Оролцогч талуудын оролцооны зураглал, матриц”
Зураг 1.



- 3.3. Компани нь оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо үүсгэхийн тулд олон улсын сайн туршлагаудыг нэвтрүүлэх ба мэдээллийн ил тод байдлыг холбогдох журмын хүрээнд хялбар аргаар олон сувгаар мэдээлэл авах боломжоор хангаж ажиллана.
- 3.4. Оролцогч талуудтай сайн харилцаа, итгэлцэл үүсгэхийн тулд оролцогч талуудын булэг, ангилал бүрд тохирсон харилцааны тодорхой стратеги, арга, хэлбэр, журмыг хэрэгжүүлж нягт харилцаж, харилцан ойлголцлыг бий болгоно.
- 3.5. Компани оролцогч талуудын санаа бодол, хүлээлт, хэрэгцээг ойлгохын тулд тэдгээрт тэдний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах сувгаар хангаж, ирсэн санал, хүсэлт, гомдлын дагуу тодорхой ажил зохион байгуулна.
- 3.6. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна. Энэхүү баримт бичиг нь нээлттэй байх баримт бичгийн нэг бөгөөд компанийн цахим хуудаст байршуулна.

ДӨРӨВ. БОДЛОГЫН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

- 4.1. Компанийн хөгжлийн стратегийг хариуцан чиглүүлэгч бүтцийн хувьд Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид ТУЗ" гэх) -нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.
- 4.2. Энэхүү бодлогыг ТУЗ батлах ба Гүйцэтгэх удирдлага нь хэрэгжилтийг хангаж оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.
- 4.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь бодлогыг хэрэгжүүлэх төсөв хуваарилж, чадварлаг, мэдлэгтэй хүний нөөц болон оролцогч талуудаас санал авах,

мэдээлэл бүрдүүлэх тогтолцоогоор хангана. Оролцогч талуудтай байгуулах аливаа гэрээ хэлцлийг энэхүү бодлогын хүрээнд байгуулна.

- 4.4. ТУЗ-ийн дэргэдэх аудит, эрсдэлийн удирдлага хариуцсан хороо нь оролцогч талуудтай холбоотой үүсэж болох эрсдэлүүдийг тодорхойлон, тэдгээрийг удирдах чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг хангуулна.

ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 5.1. “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого”-гын баримт бичгийг холбогдох хууль, тогтоомжинд заасны дагуу ТУЗ-ийн шийдвэрээр баталж, өөрчилж, хүчингуй болгоно.
- 5.2. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэнд ТУЗ-ийн дэргэдэх аудит, эрсдэлийн удирдлага хороо хяналт тавьж ажиллана.

---000---